Тайлбар

Ерөнхий хэсэг

Энэхүү барилгын дотор цахилгааны ажлын зургийг барилга, архитектур, технологийн даалгаврыг үндэслэн "Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх да угсрах" барилгын дүрэм "БД43-102-07" Цахилгаан байгууламжын дүрэм "БД43-101-03" "Байгалийн да зохиомол гэрэлтүүлэг" "БНБД 23-02-08" Барилга байгууламжын аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар" "БД 43-103-08"-ын дагуу хийж гүйцэтгэв.

Цахилгаан хангамж

Барилгын гэрэлтүүлэг болон розеткын тэжээлд гэрэлтүүлгийн самбар (ТС) Тоног төхөөрөмжинд Төхөөрөмжийн самбар (ТС), самбарыг төлөвлөсөн. Самбарууддад ВА47-100, ВА47-100, АД-12 маягын автоматуудыг төлөвлөсөн.

Гэрэлтүүлэг

Гэрэлтүүлэгчдийг өрөөний зориулалт, архитектурын шийдэлд тулгуурлан сонгосон. Сургалтын танхим,ажлын өрөөнүүдэд флюресцент чийдэнтэй гэрэлтүүлэгч төлөвлөсөн. Нийтийн эзэмшлийн хэсэг болох шатны хонгил,коридорын хэсгүүдэд лед гэрэлтүүлэгч, ослын үед асах өөр дээрээ цэнэг хуримтлууртай лед гэрэлтүүлэгчид тус тус төлөвлөсөн.

Тоног төхөөрөмжийг угсрах

Цахилгааны өрөөнд байрлах самбар нь газардуулгатай угсарсан байна. Төхөөрөмжийн самбарыг шалнаас 1.5м өндөрт, унтраалгыг хаалга онгойх талын ханаад шалнаас 1.5м-т розеткуудийг шалнаас 0.4м-т угсарна. Унтраалга ердийн розеткийг далд угсарна. Гэрэлтүүлгийн маяг, гэрэлтүүлгийн засал чимэглэлийг хийхдээ зураг төслийн зохиогчтой харилцан зөвшилцөнө. Гэрэлтүүлгүүд нь олон улсын стандартад нийцсэн байх шаардлагатай. Гэрэлтүүлгийн шугаманд ердийн нөхцөлтэй өрөөнүүдэд ПВ маркын зэс голтой утсыг ханаар шавардлага дор, таазаар хавтангийн хөндий завсраар пластмассан хоолойд суулгэж цуглагнал хучилттай өрөөнд хучилтын хавтангийн дээгүүр мөн хатуу пластмассан хоолойд суулгэж хавтанг нүхэлж угсарна. Ердийн нөхцөлтэй өрөөнүүдэд ПВ маркын зэс голтой утсыг уян пластмассан хоолойд суулгэж, шалны бэлтгэл болон ханаар ховил гаргаж далд моноглоно.

Аянга хамгаалалт, газардуулга

Уг барилга нь аянгаас хамгаалалтын ердийн хэсэгт орох да хамгаалалтын III түвшинд орно.

Барилгын дээвэр дээр 12 мм-ийн бөөрөнхий утсаар аянгын гүйдэл хүлээн авах торыг /10х10/ бүюу 100м2аас ихгүй талбайтаагаар татаж, торны зангилаа уулзвардуудыг гагнаж өгнө. Барилгын аянга хүлээн авагч нь шууд аянга буухаас хамгаалж, аянганы цахилгааны нөлөө болон аянганы цахилгааны долгион нэвтрэхээс хамгаалж потенциалыг тэгшитгэнэ. Аянгын гүйдэл дамжуулагчыг 25х4мм-ийн тууэан төмрөөр хийж барилгын ханын дагуу 20м тутамд буулгаж гадна газардуулгын системтэй холбож өгнө. Гадна дамжуулагчын шугамыг газарт 1.0м-т гүн гарган гадна газардуулгын системтэй гагнаж холбоно. Дээвэр дээр илүү гарч байгаа бүх металл эд анги жишээ нь:

агаажуулалтын металл хоолой, төмөр дээвэр, дээврийн төмөр тулгуур зэргийг аянга хүлээн авах бүслүүртэй гагнаж холбоно.

Тус барилгад TN-C-S газардуулгын системийг хэрэглэсэн. Барилгын цахилгааны самбарын дэргэд потенциал тэгшитгэх самбар /ГХХ/ байхаар төлөвлөсөн. Тус барилгын доторх байрлах потенциалын самбарыг гадна газардуулгын системтэй 40х4мм-н цайрдсан гангаар холбогдоно.

Уг барилгын цахилгаан самбарыг 25х4 мм-ийн тууэан төмрөөр дотор газардуулгын хүрээг шалнаас 0.5 м-ийн өндөрт хийж өгч, гадна газардуулгын хүрээтэй 2 цэгээр холбож өгнө.

Гадна газардуулгын хүрээг 40х4 мм-ийн тууэан төмрөөр, электродыг 25мм-ийн бөөрөнхий төмрөөр хийж өгөх да газардуулгын эсэргүүцлийн хэмжээ 4 Ом-оос хэтрэхгүй байх шаардлагатай.

Газардуулгын эсэргүүцэл нь 4 Ом-оос хэтэрсэн тохиолдолд нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай.

Угсралтыг цахилгаан техникийн ажил БНбД-305.06.90 нормын шаардлагад нийцүүлэн зураг төслийн дагуу гүйцэтгэх шаардлагатай.

-"Эко тех проект"ХХК, инженер Б.Цэрэнханд

-Архив №006/20 ,ЗТ19-1402/16

-Хөрсний төрөл – Хайргархаг элсэнцэр хөрс

-Хөрсний тооцооны эсэргүүцэл 300Ω.м

-Улиралын хөлдөлтийн гүн 2,75м

-Газар хөдлөлтийн балл 5 балл байна.

Дээрх инженер геологийн дүгнэлтийг ашиглан газардуулгын тооцоог хийсэн болно.

Цахилгаан, Холбоо дохиолол, Автоматикийн зураг төсөл Зөвлөх үйлчилгээ Утас: 99058698, 70178698	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Бичигт баг Мэдээллийн төвийн байр нэг загварын барилга				
	Тайлбар				
Инженер	Г.Золбоо	ЕГ шифр:	Масштаб: М1	Огноо: 2020.02.20	
Гүйцэтгэсэн	Г.Золбоо	ТГ шифр: ЯБ-А3-20-07	Зургийн дугаар: ХТ-02	Хуудас: 10	
"Ялгуунбаян" ХХК	Шалгасан	Б.Бат-Эрдэнэ			